

ТҮҮХ, НҮҮДЭЛ ИРГЭНШИЛ

Нүүдэлчдийн соёл иргэншил ба Монгол улс

У.ОТГОНБАЯР

1. Зохицон оршихуйн эзэмших, нутагших загвар

Хүн төрөлхтөн нь эртнийхээ уугуул унаган төрх Homo Sapiens-ийн үеэсээ эхлэн байгалийн өгөөжинд шүтэж хүрээлэн буй орчинтойгоо зохион оршиж ирсэн түүхтэйг хэн бүхэн мэднэ. Бүр эртний чулуун зэвсгийн сүүл буюу манай эрний өмнөх (МЭӨ) 2000-5000 жилд газар тариалангийн хувьсгал гүнзгийрэх тусам хүн төрөлхтний зохицон оршихуйн загвар үндсэн хоёр чиглэлээр хөгжих болжээ. Тэр үеэс хүний аймгийн нийгэм эдийн засгийн бүтцэнд ихээхэн өөрчлөлт гарч хүмүүсийн байршил зааглагдаж, анхны нийгмийн байгууламж, төр улс буй болжээ.

Их мөстлөгийн сүүл үе буюу одоогоос 12.000 жилийн тэртээ дэлхийн шим мандлын бүтэц бүрэлдэхүүнд гарсан өөрчлөлтийн улмаас газар тариалангийн хувьсгал үүсч эхэлжээ. Анхны газар боловсруулалт Дундад Дорнодод (орос нэр томъёогоор "Ойрхи Дорнод" гэдэг буй) МЭӨ 8000 оны орчимд хийгдэж улмаар дэлхийн бусад хэсгүүдэд тархахдаа газар газар өөр арга туршлагатай явагдсаар МЭӨ 2000 оны үед газар тариаланчдын хоол хүнсний үйлдвэрлэлийн гол арга болжээ.¹ Газар боловсруулан тариалан эрхлэх болсон нь хүн нийгэм харилцан адилгүй хоёр өөр замаар хөгжихөд хүргэсэн билээ.

Хүн төрөлхтөн хэсэг бүлгээрээ хамтран амьдарч, загасчлах, ан гөрөө хөөцөлдөх зэргээр хоол тэжээлээ олж орчин ахуйдаа зохицож тухайн нутаг орныхоор экологи тогтолцооны нэг хэсэг нь болсноор байгаль орчиндоо тийм ч их өөрчлөлт оруулж гай тотгор тарьсангүй. Харин газар боловсруулах болсноор хүн нийгмийн нэг хэсэг нь байгаль орчноо хувиргаж зохицон оршихуйн "эзэмших" хэлбэрт шилжжээ.

Газар тариалангийн хувьсгал юуны өмнө гол мөрний хөндий ө.х. аль үржил шимтэй, цаг уур тохиромжтой газар нутгаар түгэн тархаж, тийм нутаг дэвсгэрт үйлдвэрлэлийн илүүдэл бий болгох нөхцөлийг бүрдүүлж байв. Ууган соёл иргэншлүүд эхлээд Нил, Тигр, Ефрат, Хуанхэ, Янцзы болон Инд мөрнүүдийн хөндийд үүсч хөгжсөн нь газар тариалангийн хувьсгалтай шууд холбоотой байж ч болох юм. Соёл иргэншлийн тийм төвүүд аль хур чийг элбэгтэй, урин дулаан уур амьсгалтай газар нутаг, гол мөрний хөндийд үүсч

1 World civilizations: the classical period in world History. Chapter 4 Stearns, Peter N; Adas, Michael; Schwarts; Stearnt B. 1992 "History to the world"

хөгжсөн энэ баримт аяндаа ихийг өгүүлэх ажгуу. Үйлдвэрлэлийн нэг нэгжийн үр бүтээл, газар боловсруулж үйлдвэрлэсэн хүнс хоол хэдийгээр харьцангуй өндөр боловч уг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зарцуулсан хөдөлмөр, цагийн тоо хэмжээг мал аж ахуй, загас агнуур, ан гөрөөнийхтэй харьцуулбал хамаагүй их юм. Дээр хэлсэнчлэн газар боловсруулалт нэвтэрснээс хүнс тэжээлийн үйлдвэрлэлийн илүүдэл буй болсон нь худалдаа арилжаа нэвтрэхэд хүргэжээ. Тийнхүү нэг хүний хөдөлмөрийн үр дүнгээр өөр бусдыг тэжээх үйлдвэрлэлийн арга нэвтэрч аажмаар цаг уурын нөхцөлөөс шалтгаалан, усжуулах систем, үерийн далан мэтийг байгуулах шаардлага гарч иржээ. Тийнхүү, далан хамгаалалт, ус суваг байгуулахад олон хүний хүч хөдөлмөрийн хэрхэн зохион байгуулахтай холбогдож анхны хөдөлмөрийн хувиар гарсан байж болох юм. Чухам ийм утгаар авч үзвэл, анхны төр улс буй болсныг хөдөлмөрийн хувиар болон хүн нийгмийн анги бүлгийн давхарга үүссэнтэй шууд холбодог Марксист баримтлал хэт өрөөсгөл талтай байж ч болох юм. Ямар ч атугай, том хэмжээний усжуулах систем барих мэт нөр их ажилд олон түмний хөдөлмөрийг зөв зохион байгуулах нь яриангүй нарийн төвөгтэйгээр барахгүй удирдлагын арга ухаан шаардагдах болсон нь ойлгомжтой болно. Нийгмийн удирдлагын давхраажилт ийм замаар үүсч хөгжсөн байж болох бөгөөд зон олны хөдөлмөрийн хүчинд зориулж хүнс тэжээлийг хуваарлахтай холбогдон хөрөнгө чинээний анхны хувиар ч нэвтэрсэн байж болно. Удирдлагын систем буй болсноор нийгмийн хувиар тогтсон ба тэгэхдээ удирдлагын систем нь нэг анги нөгөөдөө хяналт тогтоох зорилгоор буй болсонгүй.

Шумер, Акад, Бабилон зэрэг бүхний мэдэх анхны хаант улсууд Дундад Дорнодын газар эдэлбэрийн бүс нутагт үүсч тогтжээ. МЭӨ 3000-аад оны үед цэцэглэн мандаж байсан Инд мөрний Харапын соёл иргэншлийн талаар тодорхой мэдээ сэлт төдийлэн байдаггүй билээ. Мөн тэр л орчим үед Нил, мөрний хөндийд Египитийн соёл иргэншил, Хуанкэ мөрний хөндийд Хятадын соёл иргэншлийн үндэс суурь тус тус тавигдаж байжээ. МЭӨ 2000 1500 оны үед Месопотам болон Египитийн соёл иргэншил Крит арлаар дамжин Европт хүрээд Балканы хойг дээр Грекийн соёл иргэншлийн эх суурийг тавьжээ. Хүн ам нэг газар олноор суурьшиж эхэлмэгц хот суурин газрууд үүсч улмаар эдийн, оюуны болон бичгийн соёлыг буй болгожээ. Суурьшмал иргэншилтэй газар нутаг нь хэмжээний хувьд тэр үедээ тийм ч их байсангүй бөгөөд байгаа нэг нь өөр хоорондоо олон мянган бээрээр алслагдан оршиж байжээ.

Суурьшмал иргэншлийн зэрэгцээгээр өвөрмөц онцлогтой өөр нэгэн иргэншил өргөн уудам газар нутгийг эзлэн гарч иржээ. Энэ нь нүүдлийн

соёл иргэншил бөгөөд түүнийг зарим эрдэмтэд суурьшмал иргэншилд шилжих шилжилтийн үе гэж үздэг байна.² Үнэн хэрэг дээрээ нүүдлийн соёл иргэншил нь өөрийнхөө онцлог замаар байгаль орчинтойгоо зохицсон хүн төрөлхтний соёл иргэншлийн нэг өөр хэлбэр юм. Нэгэнт байгаль орчноо өөрчлөхгүй, харин түүнтэй экологийн нэг систем бүрдүүлж эв зүйгээр оршин амьдрах зам буюу загварыг санаачилсан болохоор нүүдлийн соёл иргэншил нь суурьшмал соёл иргэншилтэйгээ адил хот суурин зэрэг эд өлгийн дурсгал үлдээсэн нь элбэг биш аж. Гэвч эд өлгийн олдвор ухаж малтаж олох боломжтой учраас суурин иргэдийн соёл иргэншил нь нүүдэлчдийнхийг бодвол давуу хөгжилтэй байж гэж үзэх нь учир утгагүй бөгөөд утгаа бол бичмэл ба аман соёлыг өвлөн залгамжлах хоёр өөр аргатай, хоёр өөр иргэншил, тухайлбал,

Хүн төрөлхтний, газар тариалангийн хувьсгалд хамрагдаагүй нэг хэсэг нь зэрлэг мал адгуусыг гаршуулж гэрийн тэжээмэл болгох, жилийн жилд ан гөрөө эрхлэх зэргээр хамтран бөөгнөж тухайн экологи системтэйгээ харилцан шүтэлцээтэйгээр амь амьжиргаа залгуулдаг байжээ. Зохицон оршихуйн тийм хэлбэрийг нутагших загвар гэж нэрлэдэг бөгөөд түүнийг бүтээгчид нь хүнс тэжээлийн ургамал (үр тариа мэт) буюу мал амьтан (гэрийн тэжээмэл) зэрэг байгалийн бүтээгдэхүүнээрээ амь зууж тухайн газар зүйн бүсийн байгаль орчноо шүтэн амьдардаг хүн ам болно. Тодорхой тооны хүн амыг тэжээх газар нутаг ихтэй байдаг нь зохицон оршихуйн нутагших загварын нэг онцлог юм. Гэтэл эзэмших загвар өөртөө тийм нөхцөлийг хэзээ ч бүрдүүлээгүй бөгөөд чухам үүнд уг хоёр загварын ялгаа оршино. Нутагших загвартай олонхи нийгэмүүд нүүдэлчдийн соёл иргэншилд орж нутаг нэгтний сэтгэл зүйг төрүүлжээ.

Нутагшлын загварыг сонгогч хүн ам нь байгалийн бүтээгдэхүүнээр амьдардаг болохоор хэдийгээр газар нутаг арвин ч түүний өгөөжөөс шалтгаалан тэнд амь зуух хүн амын тоо хязгаартай байв. Их Хянганы нуруунаас Алтай нуруу хүртэлх асар удам нутагт оршиж байсан нүүдэлч аймгуудын тоог л аваад үзье л дээ.

Агуу их Дорнын тал нутгийн хүн ам Хүннү гүрний үед 300-400 мянга бол Монголын нэгдсэн эзэнт гүрний үед 1,3 саяд хүрчээ.³ 1935 онд Монгол улс 750 мянган хүн амтай байв.⁴ Харин нутагшлын тэдгээр загварыг хүнээс илүү байгаль өөрөө сонгодог байж магадгүй. Нутагшлаас эзэмшлийн хэлбэрт

3. L.N Gumilev "Etnogenez I biosphera zemli" pp. 192

4. Statistical Bureau of Mongolia "Population of Mongolia" 1994 pp.g

5 Зарим газар нутаг ой модыг шатаан цэвэрлэж, хагалж дараа нь боловсруулан ашиглаад өөр нутаг усанд шилжиж очоод мөн л загвараар амьдрах жишээтэй байв. Газрын ийм маягийн боловсруулалт услалтын нүсэр том систем шаарддаггүй бөгөөд шатаасан ойн үнс чандар нь газрын бордоо болдог. Ийм маягийн зохицон оршихуй нь нүүдлийн мал аж ахуйн нэгэн адил харьяа хүн амынхаа амьжиргааны хэрэгцээг хангахын тул асар их газар нутаг шаардана.

шилжих үед зарим нэгэн завсрын шинжтэй зохицон оршихуй ёс буй болсон нь Америк, Африк болон Энэтхэгийн халуун орны ойт хээрийн нүүдэлчдийн соёл иргэншилд тусгагдсан байдаг.⁵ Хэрэв тийм нүүдэлчдийн маягийн соёл иргэншил Өмнөд Америк, Африкийн саванна буюу ойт хээрийн бүсэнд тогтсон байсан бол Евроазийн тал нутаг, Аравын элсэн цөлд нүүдлийн мал аж ахуй давамгайлж байсан ба Умард Америкт адуу, тэмээ гэх мэт сүүн тэжээлт бод мал байгаагүй боловч нүүдлийн мал аж ахуй зонхилж байжээ. /Индианчууд бух гөрөөстэйгээ цагаачилж махыг нь идэхийн хажуугаар өсгөн үржүүлж харилцан шүтэлцээтэй амьдарч байв./

Тэдгээр нүүдэлч болон хагас нүүдэлч ард түмэн говь, тал, ойт хээр, нуга хөндий бүхий өргөн уудам нутгийг эзлэн амьдарч үе үе байршлаа сэлгэж байв. Ийм нүүдэлчдийн соёл иргэншил нь газар өмчлөлийн талаар тодорхой ойлголт ч байсангүй, хувьдаа газар эзэмших хууль эрхийн тогтолцоо ч байсангүй. Гэхдээ овог аймгаараа хамтарч газар эзэмших сэтгэл зүйн үндсийг тавьжээ.

Жишээ нь: нүүдэлчдийн билчээр эзэмших сэтгэл зүй нь өөрийн онцлог шинж чанартай байв. Уг нийгмийн үндсэн баялаг болох мал сүргийг байгалийн тодорхой нөхцөлд уламжлалт аргын дагуу маллаж өсгөж үржүүлэх ёстой агаад энэ үүднээс нүүдэлчдийн хөдөлгөөний үндсэн чиглэл нь байгаль, цаг уурын нөхцөлтэй шууд холбоотой учир нүүдэлчин загварыг өөрчлөх онцын сонирхол тэдэнд төдийлөн байсангүй. Гагцхүү, ган зуд мэт байгалийн бэрхшээл, цаг уурын өөрчлөлт, дайн дажин зэргээс болж нүүдэлчид нь нүүдэл суудлынхаа хэвийн загварыг өөрчлөхөд хүрдэг хэдий ч ард түмний агуу их нүүдэл түүхэнд тийм ч олон удаа тохиолдсонгүй.

Хүннү нар Хятадыг бут цохиод эзэлсэн газар дэвсгэрээ МЭӨ 202 онд сайн дураараа эргүүлж өгөхдөө "тэд (Монголчууд) Хятадыг байлдан дагуулсан нь үнэн боловч тэнд идээшин амьдарч чадахгүй" гэж тайлбар өгчээ.⁶ Тийнхүү тодорхой хэсэг газар дэвсгэрийг энэ бидний өөрийн, хамт олных гэсэн хамтач сэтгэл зүй буй болж улмаар харь гадныхныг нутаг орноосоо үлдэн хөөдөг болжээ.

Нүүдэлч болон хагас нүүдэлч ард зоны нэг онцлог нь тэд байгаль орчинтой нэг их цаг үрж зууралддаггүй. Нүүдлийн мал аж ахуй бүр анхнаасаа цаг уурын хувьд газар тариаланд тохиромж муутай, дан ан гөрөө хөөж хүн амьтнаа тэжээх боломжгүй тийм бүс нутагт буй болсон байдаг нь тохиолдлын зүйл биш юм. Нэг үгээр хэлэхэд мал аж ахуй хуурай тал хээр, говь цөл болон Арктикийн бүснээс гадна үүссэн жишээтэй. Тухайн цаг үеийн техник, технологийн үүднээс авч үзвэл хагалж боловсруулахад тохиромжгүй тийм нутаг оронд л тэндэхийн цаг уурын нөхцөлд нь зохицсон нүүдэлчдийн амьдрал буй болж, мөн нутаг усанд тэсвэрлэж чадах гэрийн тэжээмэл малтай болжээ. Тухайлбал, төв Азид адууг тэжээвэр болгож, Арав, Сахаарын цөлд

тэмээг, Сибирийн тундрт цаа буга, умард Америкт бух гөрөөсийг тус тус гэршүүлжээ. Гэхдээ эдгээр амьтан адгуусыг гэрийн тэжээмэл болгосон түүх, соёл, тухайн ард түмний үйлдвэрлэлийн арга ёс заншил, төр улсын хөгжил зэрэг нь тус бүрдээ өөр өөр цаг үед өөр өөр замаар хөгжиж иржээ.

Нүүдлийн ба сууршлийн ийм хоёр иргэншил нь бие биенээсээ хэдэн зуун жилээр хөндийрч, тэдгээрийн хооронд үе үе тохиолддог цуст тулалдаанаас болж нэг нэгнээ ойлгохын ч аргагүйд хүрдэг амьжиргааны хоёр өөр хүн амыг бүрэлдүүлжээ. Хараппан иргэншлийг сөнөөсөн Аричуудын их нүүдэл, дээхэн үеийн Америкчуудын суурьшмал иргэншлийг хөнөөсөн Чичимегчуудын довтолгоо зэргийг дээрхийн жишээ болгон иш татаж болохсон билээ. Зарим үед нүүдэлчид суурьшмал улсыг байлдан дагуулж эзэлж аваад орон дээр нь урьдынхаас илүү хүчирхэг эзэнт гүрэн байгуулсан явдлыг түүх гэрчилнэ; тухайлбал, Хеттийн довтолгоо, Шан гүрнийг бут цохисон Чоус, Толтекчуудын эзэнт гүрэн, Азтегчууд гэх мэт болно. Гэхдээ, энэ бол суурьшмал болон нүүдэлч ард түмэн ойр хоорондоо байнга дайсганадаг гэсэн үг биш бөгөөд нүүдэлчдийн байгуулсан хүчирхэг шинэ эзэнт гүрнүүд бие биенээс алслагдан тусгаарлагдсан соёл иргэншлүүдийг хооронд нь холбож худалдаа арилжаа, шинэ үзэл бодол, техник технологийн ололтоо харилцан солилцох гүүрийн үүрэг гүйцэтгэж байсан нь бий. Мал аж ахуй нь газар тариалантай адил байнга өдөр тутмын хүч хөдөлмөр шаарддаггүй болохоор нүүдэлчид нь чөлөө цагаа ан агнуур, цэргийн сургуульд зориулж дайн тулалдааны туршлагатай болоод морь, тэмээ зэрэг тээврийн хэрэгсэл болон нум сумтайгаа нийлээд цэрэг дайны бузгай хүчин чадалтай болдог байв. Ер нь цэрэг дайны өмнөө барьдаг олонхи стратеги тактикийг нүүдэлчид боловсруулсан гэж үзэх үндэстэй агаад тэд тооны хувьд цөөн боловч унаа унашныхаа хүчээр хөнгөн шуурхай хөдөлдөг, зохион байгуулалт сайнтай болохоор суурьшмал үндэстний асар олон хүнтэй сүржин армийг ч чадамгай дарж авдаг байжээ. Манай эриний өмнөх (МЭӨ) VI зууны үед Дарий хааны арми Хар далай орчмын тал нутагт скифчуудыг хайж бэдэрч яваад амссан домогт гашуун туршлага үүний нэг жишээ болно. Иймэрхүү арга тактикийг Хятадын довтолгооны эсрэг монголчууд саяхан хүртэл нэг биш удаа хэрэглэж байлаа. Английн 5000 цэрэгтэй хүчирхэг анги нэгдэл суданчуудыг элдэж хөөгөөд төдөлгүй Нил мөрний эхэнд тулж очоод байтал суданчууд ганцхан шөнийн дотор хашир Британчуудыг төдийлэн эсэргүүцэлгүй хүйс тэмтэрсэн гэдэг.⁷ Цэрэг дайны явдалд нүүдэлчид давамгайлах болсон нь суурин төвүүдийнхний дунд айдас аймшиг төрүүлж, тэднээс зэрлэг бүдүүлгүүд гэдэг нэр хоч дуулхад хүргэжээ. Суурин иргэншлийнхэн өөрсдийнхөө түүх намтрыг бичиж үлдээсэн нь олонтой байдаг учир суурьшмал иргэдийн талаар өгүүлсэн зүйл нь ч бидний үед хүртэл залгамжлагдан иржээ.

Түүнээс гадна, нүүдэлчид нь нүглийн эздийг залхаан цээрлүүлэх гэж Яхви бурхны бүтээсэн шулмасууд гэж Библи сударч ариун Жерелж айлдсан байхад Атилла хааны хүннү нарыг Римчууд өөрсдийгөө яллахаар ирсэн шулмасын зарцууд, Атилла хаан өөрийг нь "Бурхны ташуур" гэж нэрэлжээ. Хятадууд ч ялгаагүй нүүдэлчдийг зэрлэгүүд гэдэг байж. Үнэндээ нүүдэлчдээс Чичимегийн халдан довтолсон шиг зарим байлдан дагуулалт нь суурьшмал үндэстэнд байгалийн гэнэтийн их хор хөнөөлтэй л зүйрлэхүйц зовлон гамшиг учруулдаг байжээ.

Нүүдлийн иргэншлийн үед холбогдох эртний судлалын олдвор нь голдуу яс юмуу модон сийлбэр, үнэт металлын урлал, оёмол шидмэл зүйлээр хязаарлагддаг бөгөөд тэдгээр нь цөм нүүдэлчдийн амьдрал ахуйтай нягт холбогдсон байдаг. Нүүдэлчдийн соёл, утга зохиол гэхэд л мөн тийм агуулгатай байх ба онцлог нь ам дамжин үеэс үед уламжлагддаг үлгэр, тууж, дуу, цэцэн үг болон аман зохиолын бусад хэлбэрүүд нь нүүдэлчдийн дунд түгээмэл байсныг гэрчилнэ.

Нүүдэлчдийн зөвхөн соёл ч биш, тэдний орон сууц нь хүртэл тэдний амьдралын хэвшлээс л ургаж гарсан байдаг. Жишээлэхэд, гэр майхан бол тэдний нүүдлийн хэвшилд хамгийн тохиромжтой орон сууц байж. Нүүдэлчдийн өмсөх хувцас ч гэсэн амьдрал ахуйд нь зохицсон байна. Жишээ нь урт гуятай өмдийг нүүдэлчид зохион бүтээсэн байж магадгүй юм. Морины эмээл, хазаар, дөрөөг анх тэргүүнд зохион бүтээсэн нь Төв Азийн нүүдэлчид юм. Энэ бол хүн төрөлхтний соёл иргэншлийг тухайн эд хэрэглэлээр баяжуулсан хэрэг болно. Энэ мэт хүн төрөлхтний соёл иргэншилд нүүдэлчдын оруулсан хувь нэмрийг олноор дурдаж болох бөгөөд тэдний хэрэглэж байсан буу зэвсгийн зүйл гэхэд л янз бүрийн бүс нутагт янз бүр, Тухайлбал Төв Азид илд, нум сум зонхилж байхад Африкт байсан жад, урт бамбай, Арабын элсэн цөлд илдэн жад давуу хэрэглэгдэх жишээтэй байж.

Бид одоо хөдөө аж ахуйн хувьсгал нь гол мөрний хөндийд газар тариалан, цаг уур өөртэй бусад нутаг бүсэнд мал аж ахуй хөгжүүлэхэд хүргэж улмаар эзэмших буюу нутагших хэмээх зохицон оршихуйн хоёр өөр хэлбэрийг үүсгэжээ гэсэн дүгнэлт хийж болох юм. Энэхүү хоёр загвар цаашдаа амьжиргааны хэрэгсэл болж газар тариалан ба мал аж ахуй хоёрыг хөгжүүлэхэд хүргэж эцсийн бөлөгт суурьшмал ба нүүдлийн хэмээх иргэншлийн хоёр өөр хэлбэрийг буй болгожээ.

2. Нүүдлийн иргэншил, түүний гол хэлбэрүүд

Хүн төрөлхтөн малыг чухам хэзээ гэрийн тэжээмэл болгосон тухай мэдээ сэлт ховорхон байдаг юм. Өөрөөр хэлбэл аль үеэс мал нүүдэлчдийн амьжиргааны эх булаг болсон нь төдийлэн тодорхой судлагдаагүй ажээ. Харамсалтай нь нүүдлийн иргэншил амьдрал ахуйнхаа талаар үлдээсэн бичмэл түүх маш хомс бөгөөд зөвхөн цөөн тооны бичиг дурсгал нь цаг хугацаа болон байгалийн сорилтыг давж та бидэнд өвлөн уламжлагджээ.

Ойролцоогоор МЭӨ 2000 жилийн үед хонь, ямаа, үхэр, адууг гэрийн тэжээмэл болгосон гэж эрдэмтэн мэргэд үздэг байна. Малаар амьдрагчид нь гол мөрний хөндийд сууж газар тариалан эрхэлдэг хүн амтай нэг дор нутаглах аргагүй байж. Учир нь тэдний мал сүрэг нь өргөн уудам билчээр нутаг шаардах учир малынхаа аяыг дагаж газар тариаланд тохиромж муутай ч үе үе нутаг билчээрээ сэлгэж нүүж суух замаар малаа тэжээгээд байж болох гандуу ба хагас-гандуу нутаг усыг бараадах болжээ. Тэд харин мал аж ахуй эрхлэхийнхээ хажуугаар ав хомрого зохиож ан гөрөө хийж амьдралдаа нэмэрлүүлэх аргыг нээжээ.

Нүүдлийн мал аж ахуй малчдын нийгмийн сэтгэл зүйд ноцтой нөлөөлөх болжээ. Газар тариалан зонхилсон нийгмийн дотор "хүн-газар" гэсэн харилцаа нийгмийн сэтгэл зүйд давамгайлж хувьдаа газар эзэмших хэв ёсыг үүсгэсэн бол нүүдлийн иргэншилд "хүн-мал" гэсэн шугамаар малыг эзэмших явдал хөгжиж улмаар "хүн-мал" шугам нь "отог аймаг-нутаг билчээр" эзэмших хэв ёс буюу загвар тогтож мал, нутаг билчээрийг хэсэг бүлгээр эзэмших болжээ. Газар тариалан бүхий нийгэмд хамтын хөдөлмөр ялангуяа үерийн далан, услах систем барих зэрэг цаг үеийн ажилд хурцаар шаардагдах болж, хэрэв нүүдлийн иргэншилд хувь хүн шийдвэрлэх нөлөө үзүүлсэн бол суурьшмал иргэншилд нийгмийн байгууллага шууд нөлөөлөх болжээ. Нүүдэлчдийн дээр дурдсан хамтач чанар нь малын билчээр эзэмших, хараат эзэндээ үнэнч байх хандлага зэрэг дээр илэрдэг байсан ба найр хурим, наадам цэнгээ, уул овоо тахилага, дайн тулаан ав хомрогын цагт нүүдэлчдийн өргөн цуглаан байжээ.

Хатуу ширүүн уур амьсгалын нөлөөн дор нүүдлийн иргэншил нэр бүхий гэрийн тэжээмэл амьтадтай харилцан, шүтэлцээ буй болгожээ. Евроазийн тал нутаг, Араб ба Сахарын элсэн цөл нь хур тунадас багатай, өдөр шөнийн хэм эрс ялгаатай учир газар тариалан эрхлэхэд тохиромжгүй болохоор нүүдэлчид нь гэрийн тэжээмэл амьтад болох мал сүргийнхээ эрхээр өвс, устай нутагруу шилжин нүүцгээсэн бол зүүн Африкийн нүүдэлчид "цэцэн ялаа"-ны төрхийн нүүдэл хийх хэрэгтэй болжээ.

Нүүдлийн иргэншлийн хамгийн сонгодог жишээ бол Евроазийн тал нутгийнхан адууг гэрийн тэжээмэл болгож хүн адуу хоёр харилцан шүтэлцээтэй амьдрах болсон явдал юм. Бидний мэдэхээр түүхэнд тэмдэглэгдсэн анхны нүүдэлчид бол МЭӨ 2000-аад жилийн тэртээ Ойрхи дорнодод байсан Индо-Европчууд ажээ. Хетт, Хиксосууд эзэнт гүрнээ байгуулж, Грегчүүдийн өвөг дээдэс Грец рүү нүүдэл хийж шинэ маягийн суурьшмал иргэншил тогтоожээ. Нүүдэлчин скифууд хожим бага Азийг чичрүүлж, Кушанчууд Төв Азиас Энэтхэгийг хүртэл тэлсэн эзэнт гүрнийг байгуулжээ. Аричууд Гиндкушийг давж нүүдэл хийгээд алдарт Харалпын иргэншлийн эхийг тавьжээ. Эдгээр бүх нүүдэлчид нь урьд хүн төрөлхтөн зохион бүтээсэн морь тэргээр хөлөглөн давхицгаадаг байжээ. Сүүлээр эмээл, хазаар, эмээлийн дөрөө хэрэглэдэг болсон цагаас хойш морьтон нүүдэлчид

дэлхийн түүхэнд бүр ч хүчтэй нөлөөлж эхэлсэн.

Төв Азийн анхны ууган морьтон хүннү нар хятадыг айлгаж, хүлгийн жолоог Өрнө зүгт залж Готуудыг нутгаас нь хөөгөөд Римийн эзэнт гүрнийг мөхөлд хүргэжээ. Түүнчлэн, Энэтхэгийн Гута улсыг эвджээ.

Нүүдлийн аргат үйлдвэрлэлд адууг гэрийн болгосон явдал хувьсгалын чанартай асар их нөлөө үзүүлж тэдгээрийн цэргийн сүр хүчинд чухал түлхэц болсон юм. Адууг гэрийн болгосон газар нутаг Европ, Азийн янз бүрийн соёл, иргэншилтэй шууд хаяа нийлэх болсон дэлхийн түүх, ялангуяа цэрэг дайны салбарт асар их нөлөөлж шинэ цагийн галт зэвсэг, аж үйлдвэрийн хувьсгал болох хүртэл дэлхий дахинд ноёрхсоор иржээ.

Лапландерчууд, Якут (Яхадчууд), Чугчагчуудийн хувьд бол тэдний соёл иргэншил цаа буга дээр үндсэлсэн байдаг. Эдгээр үндэстнүүд газар зүйн хувьд соёл иргэншлийн бусад төвүүдээс тусгаарласан болохоор дэлхийн түүхэнд төдийлэн нөлөөлсөнгүйгээр барахгүй түүх шаштарт тэмдэглэгдсэн нь ч ховор ажээ.

Арабын хойг, Дорнод Африк, Сахарын элсэн цөлд нүүдэл иргэншлийн гол мал нь тэмээ болжээ. Тэмээг унаа хөсөгт ашиглах болсон үеийг МЭӨ 1700-аад он гэж Мисирийн он дараалалын бичигт тэмдэглэжээ. Адуу аажмаар цөл болон цөлөрхүү бүсэд нэвтэрсэн хэдий ч тэдгээр бүс нутгийн нүүдэлчдийн амьдралд үзүүлсэн нөлөө ач холбогдлоороо тэмээг гүйцсэнгүй.

Энэ нь цөл хээрийн бүсэнд тэмээ шиг зохицсон мал байхгүй гэдгийг харуулна.

Нил мөрний эх хийгээд өнөөгийн Судан улсын өмнөд нутгаар нүүдэлчид бог малыг голдуу гэрийн болон өсгөж үржүүлжээ. Нутаг бэлчээр цаг уурын онцлог зэргээс болж энэ бүс нутагт адуу төдийлэн үүрэг гүйцдэгсэнгүй, харин бог мал уг нутгийнхны амьжиргаа болж малчид нь малаа явган хариулсаар иржээ. Газар зүйн байршлаар иргэншсэн төвүүдээс зайдуу зэрэг шалтгаанаар тэдгээр нүүдэлчдийн талаар мэдээ мэдээлэл тийм ч элбэг бус ажээ.

Их мөстлөгийн дараах үед умард Америкт асар олон сүүн тэжээлтэн устсан түүхтэй бөгөөд харин тэр нутгийн нүүдэлчид тэмээн гөрөөсийг гэршүүлж амжжээ. Уг нутгийн индианчууд бух гөрөөсийг нүүдэл суудалдаа ашиглаж байсан хэдий ч адуу тэмээ шиг гэршүүлж хараахан чадсангүй.

3. Евроазийн талын морьтон соёл иргэшил

Нүүдэлчдийн түүхэнд Евразийн талын үзүүлсэн нөлөө

Тундр болоод элсэн цөлийн хуурай бүсийн хоорондох өргөн уудам газрыг Евроазийн тал эзлэнэ. Өрнөдийн их тал хээр нь Дунай мөрөн, Хар тэнгисийн Умард эргээс ижил мөрний адаг, Уралын уулсыг дайрч Алтайн нуруунд тулж очно. Дорнодын их тал нь Алтайн нурууны зүүн хэсгийн тэгш талаас эхлээд Их Хянган нуруунд хүрнэ. Дээр дурдсан Өрнөдийн тал нутагт Бага Азийн багавтар талууд орох ба Дорнодын тал нутагт Манжуурын тал багтна. Харин үүнтэй холбогдуулж хэлэхэд Европ Азийг Уралын нуруугаар

заагладаг нь нүүдэлчдийн хувьд ямар ч утга учиргүй бөгөөд нүүдэлчдийн хөдөлгөөн, их нүүдэл, дайн байлдаан зэрэг нь цөм л энэхүү хүн-зохиомол хил хязгаарыг хөндлөн гудас дайрч өнгөрч байжээ.

Өрнөдийн талын цаг уур нь хур тундас ихтэй, нэлээд чийглэг учраас мал аж ахуйн хажуугаар газар тариалан эрхлэх боломж олгожээ. Энэ бүс нутгийнхны адууны үүсэл нь түрэг, татар аймгийн зэрлэг адуу (тарпан) байж болох юм. Тэгээд морь тэрэг хөллөсөн Хиксос, Хетт, Акад, Скифийн дайчин эрс морин цэргийнхээ давууг ашиглаж Дундад Дорнод, Бага Ази, Мисирийн суурьшмал эзэнт гүрнүүдийг амжилттай дайрч довтолж байсан түүхтэй. Карпатын уулсаар тусгаарлагдсан Унгарын тал нутаг, гол үндсэн тал нутгаас Кавказын нуруугаар тусгаарлагдсан Иран, Бага Азийн тал нутагууд нь манжуурын тал нутаг лугаа нэгэн адил цаг уурын хувьд тохиромжтой бөгөөд тийм ч учраас дорно зүгийн нүүдэлчдийн анхаарлыг хэзээнээс нааш татаж иржээ. Дорнын талууд нь Алтайн нуруугаар хаагдаж хур бороо, өрнөдийн дулаан урсгал (муссан)-д хүртээл муутай, дорнын дулаан урсгалыг Их Хянган нуруу хаах учир өдөр, шөнө өвөл зун нь эрс ялгаатай хуурай цаг ууртай, манай дэлхийн хамгийн ширүүн хатуу уур амьсгалтай бүс ажгуу. Прежвалскийн адуу буюу тахь Дорнын талд анх түрүүн гэрийн тэжээмэл болсон байж магадгүй. Зарим жилд аюултай ган гачиг болж нутаг билчээр, ус ундыг сүйтгэдэг учир нүүдэлчид Их Хянган нурууг давж зүүн тийш Манжуурын тал руу болон Зүүнгарын хаалгаар (Алтай, тэнгэр уулын завсараар) гарч Өрнөдийн талууд руу нүүдэллэх нь олонтой байжээ.

Өрнөдийн талуудад Индо-Европ болон Семитик нүүдлийн уламжлал хөгжсөн бол дорнын талуудад Түрэг, Монгол нүүдэлчин заншил тогтжээ.

Адууг МЭӨ 2000-аад оны үед гэрийн тэжээмэл болгосон гэж Археологийн судлал нотолдог байна. Малын сүү болон сүүн бүтээгдэхүүн ашиглах болсон нь мал аж ахуйд хувьсгалт өөрчлөлт оруулж нүүдэлчдийг хүнс тэжээлээр байнга хангах эх булгийг нээжээ. "Сүүн хувьсгал" нь эхлээд өрнөдийн талуудад МЭӨ 2000 оны үед гарсан нь дэлхийн байлдан дагуулалтын идэвхжилт, өрнөдийн нүүдэлчдийн их нүүдэлтэй давхцдаг юм. Индустаны хойг руу Аричууд Ираны ам уулсыг даван нүүсэн ба зарим нь Европыг зүглэжээ. Мөн үед скифууд Ассирийг идээд Перс рүү довтолж байв.

Өрнө, дорнын тал нутагт хүчирхэг улсууд буй болсон нь хил зэргэлдээ орнуудын суурьшмал үндэстний дунд том том эзэнт гүрнүүд үүссэн үетэй давхцсан байдаг нь тохиолдлын хэрэг биш бололтой. Өрнөд Азид Ассири, Персийн эзэнт гүрнүүд ноёрхож байх үед өрнийн талд Скифчүүдийн нягт холбоо гарч ирээд Ассирийг арчин цэвэрлэж, Персийн дайралтыг амжилттай няцааж эхэллээ. Хятадад Цинь, Хань улсууд үүсэн байгуулагдах үеэр Дорнын талд Хүннү нарын нягт холбоо гарч иржээ.

Персийн эзэнт гүрний туурин дээр байгуулагдсан Парфяны хүнд хуяг дуулгат морин цэрэг нүүдэлчдийн дайралтыг сүрхий няцаадаг байж. Парфяны морин цэргийн амжилтын нууц нь Ираны дов толгодод газар

хагалж шар царгас тариалж адуугаа тэжээдэгт байжээ. Шар царгасаар тэжээсэн бие томтой адуу хүнд хуяг дуулга өмсч илд бамбайгаар зэвсэглэсэн дайчин эрсийн найдвартай хөлөг болж чаджээ. Иранийн уул толгодод нэвтрэх аргагүй зам нь хаагдаж, дайралт нь амжилт олоогүй өрнийн талын нүүдэлчид тэгээд худалдаа арилжаанд гол анхаарлаа хандуулж эхэлжээ. Чухам энэ үеэс эхлээд нүүдэлчид чухал хэрэгцээт эд бараагаа суурьшмал иргэншилт газар орноос олж авахад алдарт торгон зам асар их үүргээ гүйцэтгэх болжээ.

Манай эриний эхэн үеэр дорнодод Хүннү нарын нягт холбоо, Хятадын Хань улсын аль алины нь задрах үйл явц эхэлжээ. Хүннү нарын нягт холбооны уналт нь Дорнын тал нутагт ихээхэн ган гачиг болдог болсонтой холбоотой байсан байж болох юм. Умрын хүннү нар зүүн гарын хаалгаар гарч өрнийн тал нутагт очоод тэндхийн Сармат, Готчуудыг хөөж гаргаад 370-аад оны үед Дон мөрнийг гаталж 376 орчим Римийн эзэнт гүрний хилд тулж очжээ. Умрын хүннү нар үнэндээ Римийг эзлэн дагуулахыг хүссэнгүй, зөвхөн үе үе дайралт хийгээд эд агуурс олзлох зэргээр хязгаарлаж өөрсдөө цаг уур, өвс билчээр тохиромжтой Унгарын тал нутагт суурьшжээ. Гэвч умард хүннү нарын эзэнт гүрэн Германы омогийнхны бослогоноос хойш ноёрхол нь унаж, аажимдаа эзэнт гүрэн нь алга болжээ. Ижил мөрнөөс Алтай хүртэл зонхилж байсан цагаан хүннү буюу ефталитууд бусад омог аймгийнханд цохигдож Хиндгүүшээр даваж Индустаны хойг руу нүүжээ. Харин Өмнөд Азийн халуун орны уур амьсгалд адуу мал нь тэсээгүй учраас унаагүй хоцорсон цагаан хүннү нарын цэргийн сүр хүчин унаж аргагүй эрхэнд суурьшмал амьдралд шилжжээ. Дорнын тал нутаг эзгүүрэх шахаж, Өмнийн хүннү нар хятадын түмэн газрын цагаан хэрэмнээс урагш нүүдэллэж эхэлжээ.

Манай эриний V зууны үед дорнын тал нутагт зонхилох хүч нь Жужанчууд болж байх цагт Өрнийн тал нутагт нүүдэлчдийн задрал үргэлжилсээр байв. Гэвч Жужанчууд тийн удалгүй ноёрголоо Түрэгүүдэд алдаад өрнийн тал нутаг руу нүүн Одсон 30 мянга орчим айл өрхийн хүн ам аварууд нэрийг авчээ. V зууны дунд үеэр Түрэгүүдэд түрэгдсэн аварууд Унгарын тал нутагт хүрч тогтжээ.⁸ Жужанчуудын цэрэг эрсийн хүчин доройтлыг их талын ган гачиг, хүн амын цөөрөлтөөр тайлбарлаж болно. Тийнхүү, Шэлун хаанаас хойш Жужанчууд тал нутагт ноёрхох чадалгүй болсон байна.

Хятад хүчирхэг Суй улс байгуулагдаж түмэн газрын цагаан хэрэмнээс ар тийш түрэмгийлэх бодлого явуулах болсон учир тал нутагт эсэргүүцэх чадалтай нягт холбоо байгуулах шаардлагатай болжээ. Золоор хур тундас элбэг бууж, билчээр нутагт элэгдэхийн зэрэгцээ хүн амын өсөлт ч нэмэгдэх болсон нь Дорнын талд зэгсэн олон тооны морин цэргийн армитай байх боломжийг олгожээ. (Оросын эрдэмтэн Л.Н.Гумилевын тооцоолсноор

Дорнын тал нь II-V зуунд ган гачиг ихтэй, хуурай, VI-VII зуунд хур дундас нэмэгдэж X зууныг ирэхэд үржил шим сайтай нутаг болж адуу мал үржүүлэхэд тохиромжтой болжээ.⁹ Энэ үеэс Дорнын талд Түрэгийн нягт холбоо хүчтэй болж тэдний зарим нь Өрнийн талд ч нэвтрэх болжээ. Түргүүд Булгар, Печенег, Хазаруудыг Каспийн эргээс баруун тийш хөөсний дүнд Авар, Мажар хоёр Унагрын талд тогтож Балканы хойгт Болгарчууд Хар далайн эргээр Хазарууд нутаглах болжээ.¹⁰

Хүнд хуяг дуулгатай морин цэрэг VII зууны үед Европт гарч ирснээр нүүдэлчдээс баруун тийш хийх давшилт хаагдаж, тэд жолоогоо Иран бага Ази тийш залж эхэлжээ. Энэ үед Сасанидийн цэргийн эрхтэнүүд Парфянгуудаас өвөлж үлдсэн морин цэргийн сургуулиа мартсан учир нүүдэлчдийн зөөлөн зууш болж байлаа. Түрэгүүд Жужаны хил хязгаарт тулж ирээд зогссонгүй улам баруун тийш Иран, Баруун Ази тийш давшилтаа үргэлжлүүлжээ. Сүүлд лалын шашинд орсон Түрэгүүд хөлсний цэрэг болж хувирч Энэтхэгийн салбар тив, Европ аль алинд нь дайчлагдаж байв.

Нэг овог аймаг, нэг бүлгийнхний ноёрхол Дорно, Өрнийн тал нутгийн аль алинд нь тогтсоноор Лалын ертөнцтэй хэлхээ холбоог нь идэвхжүүлж Их торгон замын чиглэлийг өргөтгөжээ. Дорнын тал нутагт Түрэгийн хаант улсын нөлөө буурсны дараа Хятадын Тан улс самуурч Хятадыг захирах эвдэрсэн эрхээ Уйгарын нүүдэлчдийн тусламжтайгаар сэргээх оролдлого хийж байлаа.¹¹

Дорнын тал нутагт ноёрхож байсан Уйгар, Киданы хожуу үеийн нягт холбоод хятад зэрэг янз бүрийн улсуудтай байнга тэмцэлдэж байлаа. Умард Хятадыг захирч байсан Киданы Лиано улс аажмаар хятадчлагдаж улмаар манжуурын тал нутгийн Жүржээн(зурчид)-чууд бут цохигджээ. Зүрчидийн Алтан улс Умард Хятадыг ноёрхож байх зуураа өмнө талын Сүн улстай олон удаа байлдсан боловч Өмнө газрын ой шугуйт нутагт морин цэргээр төдийлэн амжилт олсонгүй.

X зуунд оршиж байсан Монгол аймгуудын нягт холбоо Чингис хааны үеийг хүрч иртэл түүхэндээ онцын ач холбогдолтой үүрэг гүйцэтгэсэнгүй.

Нүүдэлчдийн хүчирхэг гүрнийг байгуулж чадсан хүн бол Чингис хаан юм. Монголын их эзэнт гүрэн байгуулагдсан явдлыг зөвхөн Дорнын тал нутгийн цаг уурын сөрөг өөрчлөлтөөр биш, басхүү XIII зууны үед хур тунадас элбэг их болсон эерэг нөхцөлөөр тайлбарлах нь илүү учир утгатай бол уу. Монголын тал нутагт XII зууны үед Монгол, Хэрээд, Нийман аймгуудын нягт холбоо ноёрхох болсон тэр үед Дорнын талд барагцаалбал 180-200 мянган цэрэг эрс тулалдаанд ордог байсан бололтой байдаг.

9. L.N.Gumilev." Etnogenez | biosphea Zemei (Угсаа гарвал ба шим мандал) 194-195 дахь талууд

10. Bretanica Encyclopaedia. vol 28. p 245

11. Ebid, vol. 28 p. 246

Чингис хаан 1206 онд 95 мянгат байгуулж байх үед урьд нь байгуулсан хуучин мянгатууд байсан ба тэд 1204-1206 онд хэрээд, найман, мэргэдүүдтэй цус урсгасан дайн хийж байжээ. Энэ дайны хөлд үй түмэн хүмүүс үрэгдэж, хүн амын тоо багагүй хорогдсон нь мэдээжээ.

Үл дуусах өш хонзон, харилцан дайсагналаас болж цэрэг армия хэзээ ямагт бэлэн байлгах шаардлын үүднээс Дорнын талд 3-4 армитай байхыг зөвшөөрдөг байжээ. Тийм ч учраас цус урсгасан дотоодын дайны дараа ч Монголчууд 100 мянга хүртэл цэрэгтэй армит зүрчидийн Чин улсын эсрэг хөдөлгөж амжиж байжээ.

Гэвч энэ бүхэн бол газар зүй болон цаг уурын нөхцөл л нүүдэлчдийг соёл иргэншлийн суурьшмал төвүүдийн эсрэг тухиран дайсагнуулсан гэсэн үг хараахан бишээ. Түүнчлэн ард түмний их нүүдэлтэй XII зууны Монголын байлдан дагуулалт тийм ч их холбогдол байхгүй. Энэ бол хэрэг дээрээ хорвоо дэлхий нь бидний ноёрхолын төлөө бүтээгдсэн юм гэж үнэн голоос итгэсэн Монгол хаадын сайн зохион байгуулж, төлөвлөн адал явдал гэвэл арай дөхөж очих талтай. (Монголын их хаан Гүюгээс Римийн Пап ламд бичсэн захидалдаа: "...Их тэнгэрийн хүчинд нар гарахаас нар шингэх хүртэлх бүх газар нутаг бидэнд захирагдах ёстой...")¹² гэсэн байдаг. Гэхдээ нүүдэлчдийн хүчирхэг гүрэн үүсэхэд их талын газар зүй, уур амьсгалын нөхцөл зохих нөлөө үзүүлсэн тодорхой бөгөөд зарим тохиолдолд их нүүдлийн аян дайны анхдагч шалтгаан ч болж байжээ.

4) Дорнын талын нүүдэлчдийн төр улс үүсэх үйл явц

Дорнын тал нутагт нүүдлийн эзэнт гүрнүүд гарч ирсэн явдлыг ойлгохын тулд тэдний эдийн засаг, соёл болон ураг төрлийн ёсыг харж үзэх ёстой.

Хэдийгээр адуу биш харин хонь, ямаа тус бүс нутгийн нүүдэлчдийн хүнс хоол, түүхий эдийн гол эх булаг болж байсан боловч нүүдэл суудал, дайн дажны хөлөөс зугадах, суурин газар орон руу дайралт хийх зэрэгт унаа хөсгийн гол хэрэгсэл нь адуу байсан учраас морь хүн хоёрын шүтэлцэн оршихуйг буй болгожээ. Эмээл, дөрөө хоёрыг анх түрүүн Төв Азийн нүүдэлчид зохион бүтээхдээд зэргийн үр ашигтай хөнгөн морин цэргийг чадварлагаар зохион байгуулж, дайн тулаанд цоо шинэ тактик нэвтрүүлсэн нь үнэний хувьтай байж болно. Ан гөрөө хийж ирсэн мянга мянган жилийн туршлагаар нүүдэлчид хүчирхэг нум сумтай болсон нь тэдний гол зэвсэг байсан бөгөөд Чингисийн чулууны бичгээс үзэхэд 600 м хол харваж чаддаг байжээ.

Цаг уурын хүнд нөхцөл нь нүүдэлчдийн хүчтэй нь үлдэх байгалийн шалгарлын хайр энэрэлгүй жам ёсонд оруулж улмаар нүүдэлчдийн нийгмийн зохион байгуулалт, иргэншлийн нэг томоохон шалгуур болжээ.

Ажиллах хүч хангалттай суурьшмал иргэншлийн нөхцөлд шинэ газар олж боловсруулах эрмэлзэлтэй байдаг бол нүүдэлчид билчээрээ алдвал үхэлтэй адилхан байдаг аж. Үхэх сэхэхийн ирмэг дээр байлгадаг байгалийн шалгарлын ийм нөхцөл, түүний хажуугаар тасралтгүй үргэлжлэх дайн тулаан нь нүүдэлчдийн дунд эр зоригийн соёлын хөгжилтийг хөхүүлэн дэмжихийг шаарддаг байна. Тийм ч учраас нүүдэлчид зориг зүрх, хүч чадал хийморийг өндөр үнэлдгийг ардын аман зохиолоос мэдэж болдог. Нүүдэлчид эр зоригийн соёлын ёсоор тодорч гарсан бяр тэнхээтэй, сэргэлэн цовоо, шулуун шударга хүмүүстээ хичнээн хүндэтгэл үзүүлдэг заншилтайг Чингис хаан шадар туслагч нарынхаа ач тусыг магтан сайшаасан үгнүүдээс мэдэж болно. Тийм хүмүүсийнхээ гавъяа зүтгэлийг тэмдэглэсэн үгэнд дараах мэт үнэлэлт байдаг нь: "... нойтонд норолцож, хүйтэнд хөрөлцөж... алалдхуй өдөр, амиа өргсөний тул, үхэлдхүй өдөр, өрсөлдсөний тул..Хатгалдахуй өдөр халх болсоныг, дайсан хүмүүнд, далдлагч болсоныг, хагацсан улсыг хамтатгасны бутарсан улсыг бүрэн болгосны..."¹³

Хатуу ширүүн уур амьсгал, эр зоригийн соёл нь нүүдэлчдийг зочноо хүндэлдэг заншилтай болгожээ. Зэрлэг бүдүүлэг ширүүн догшин нэр хүлээсэн нүүдэлчид маань зэвсэггүй орж ирсэн хүнийг хороох, хорлох, доромжлохыг үл өршөөх гэмт хэрэг гэж хатуу цээрэлдэг аж. Эр зориг, бардам зан, цог заль итгэл зүтгэл, удирдагчаа эрхэмлэн хүндлэх ёс энэ бүхэн нь нүүдэлчдийн сэтгэл зүйн салшгүй хэсэг юм.

Нүүдэлчид нь ураг төрлийн хамаатай цөөн өрх гэр бүлээр амьдрах бөгөөд тэдний тоо голдуу 10-20 зарим нь 100 хүртэл айл байх жишээтэй. Ураг төрөл нь нүүдэлчин аймгийн үндсэн нэгж бөгөөд нэг өвөг дээдсээс гаралтай омог аймгийг бүрдүүлнэ. Харин билчээр нутаг, өвөлжөө хаваржаа зэргээсээ болж бие биенээ дайсагнах явдал нүүдэлчдийн дунд байнга гардаг бөгөөд энэ нь тэдний нэгдэл хягтралд саад учруулдаг байж. Ураг төрлийн ёс, бардам зан ойр хоорондын эвдрэл хагарлаас болж үе дамжсан өшөө хорсолд хүрэх нь ч байдаг. Нүүдэлчин нийгмийн үндсэн нэгж нь эдийн засгийн хувьд өөрийгөө хангаад байдаг учир хамтрах хамтын хүч хөдөлмөрийг чухалчлах шаардлагагүй байдаг бөгөөд нүүдэлчдийн нэгэн жигд, амиа аргацаах хандлагатай болгодгоороо эв нэгдэлд нь эсрэгээр нөлөөлдөг байна.

Омогийн нягт холбооны зохион байгуулалтын дээд тогтолцоо нь омог аймгийн удирдагчдын шугамаар явах ба удирдлагчид нэр төртэй, үнэнч шударга захирагдах сэтгэлзүйгээр хүмүүжигднэ. Мэргэдийг дарсаны дараа Тэмүүжин, Жамуха хоёр гал тусгаарлаж буух болсонд Жалайр, Дархад, Ганишут, Баяуд, Барулас, Урианхай, Бэсүд, Хонхотон, Сүхэчэн, Олхунуд, Горлос, Ихирэс, Ноёхон, Ороچار, Баарин аймгийн өч төчнөөн тэргүүн түшээ нар ах дүүгээрээ дээрэх хоёр анд нөхөдийн хэнд нь ч, хар буруу санахгүй

13. Secret History of the mongols-London.pp. 147-150 /Орчуулгыг Далантайн Цэрэнсодномын "монголын нууц товчоо"-ны орчууллагын тайлбар. Бээжин 1993 хар ярианы хэлээр буулгалаа. Номын 192-195 дахь талууд/

Тэмүүжинг дагажээ.¹⁴

Өөрөөс нь албатууд нь хөндийрсэн явдалд Жамуха баярлахгүй нь мэдээж бөгөөд гэвч Тэмүүжин Монголын хаан ширээнд улам дээш ахих төлөв, түүний албатуудын гарт дүү Тайчар нь үрэгдсэн явдал зэрэг нь Жамуха Тэмүүжинтэй тэрсэлдэж албат иргэдээ эргүүлж авах буюу Тэмүүжинг яллах шалтгаан болоогүй юм.

Нүүдэлчдийн төр улс нь хамт олонч сэтгэл зүйчээр давуу байдаг суурьшмал төвүүдийн төр улсаас зарчмын ялгаатай байдаг юм. Нүүдлийн нийгэмд төр улс байгуулагдахын үндэс суурь бол удирдагчдаа болон омогийн тэргүүндээ шууд захирагдна гэсэн тангараг өргөх ёс, ав хомрого, дайн тулаанд тусгай шаардлагатай бол омог аймгийнхныг нь зарлан дуудах журмаас эхлэнэ. Их хэмжээний морин армийг нэг газар, удаан хугацаагаар байрлуулж байх нутаг билчээрийн зэрэг боломж тал нутагт бэрхшээлтэй байдаг бөгөөд гагцхүү Чингис хааны хишигтэн, хэвтүүл (бие хамгаалагч) зэрэг цөөн тооны цэргийн хүч нь байнгын үүрэг гүйцэтгэнэ. Дундад зууны үеийн Европт эзэн албатын ёс хатуу байсныг хууль цаазын бичигт тэмдэглэсэн ба цэрэг татлага зөвхөн дайн байлдааны үед явагддаг байжээ. "Монголын нууц товчоо"-нд Тэмүүжинг Монголын хаанаар өргөмжлөхөд Алтан, Хучир, Сача бэхи нар дараах тангарагийг өргөсөн нь:

"Олон дайнд оройлон явж, онц гуа охидыг олзолж, ордон сайхан гэрийг авч олны хаан Тэмүүжинд чамд өгье, харийн иргэнийг халдан довтолж, хацар гуа хатадыг олзолж, хатир сайт агтыг хөөж авчирч өгье. Ороо гөрөөсийг авлах цагт, отож ойртуулж өгье бид... хатгалдах дайн болох цагт, хаан Тэмүүжин чиний хатуу зарлигийг хайхрахгүй явбал, хатан эмээс хагацуулан салгаж, хамаг юмыг хамран авч, хар толгойгий минь хаяж одогтун, энэ цагт эзэн Тэмүүжин чиний эе зарлигийг эс дагах бол, эзэлсэн ардыг авч эм хөвүүдийг булааж, энэ биеийг минь эзгүй газар хөөж орхи¹⁵ гэсэн нь эзэн албатын харилцааны хэм хэмжээг харуулжээ.

Нүүдэлчдийн хатуу төр улс нь тэдний амьдралын шаардлага, ялангуяа гаднын найрсаг бус хандлагатай тулгарсан нөхцөлд бүрэлдэн тогтжээ. Нүүдэлчид нэг газар их хэмжээний хүн хүч, адуу мал барьж байх боломж муутай болохоор гагцхүү дайн байлдааны үед цэрэг армия бүрэлдүүлэх зэрэгт хатуу засаг хууль, төр улс хэрэгтэй нь ойлгомжтой билээ.

14 Secret History of the Mongols. London, 1982. pp. 51-52

15 Secret History of the Mongols. London, 1982. pp. 54-55 Орчуулгыг "Монголын нууц товчоо" (Ц.Дамдинсүрэнгийн орчуулга УБ. 1990 74-75 дахь талаас авлаа орч/

Хятад	Төв Ази
МЭӨ 221-206 Цин улс	
МЭӨ 260-МЭ 220 Хань улс	МЭӨ 209-МЭ 53 Хүннүгийн эзэнт гүрэн
220-589 Бутралын үе	53-453 Умард Хүннүгийн эзэнт гүрэн 150-235 318-410 Моюун улс 307-581 Тоба улс 402-555 Жужан улс
589-619 Суй улс	552-630 Түрүү үеийн түрэг улс
618-907 Тан улс 755 онд дэгдсэн Лушааны бослого Тан улсыг арчих дөхсөн бөгөөд Тан улс гагцхүү Уйгарчуудын тусламжтайгаар зонхилох байр сууриа хадгалж үлдсэн	693-745 Хожуу үеийн түрэг улс 745-840 Уйгар улс 840-90 Киргиз улс
907-960 5 улсы үе	901-1125 Китан улс
960-1275 Сун улс	1122-1368 Зүрчидийн чин улс 1206 Монголын эзэнт гүрэн
1214-1368 Монголын ноёрхол, Юан гүрэн	

Хятадад хүрчирхэг эзэнт гүрнүүд гарч байсан үетэй нүүдэлчдийн хүчирхэг улсууд давхцаж үүссэнийг бид дээрх хүснэгтээс харж болно.

Нүүдэлчин аймгуудын нягт холбооны нэг удирдагч ялагдлаа гэхэд хүчирхэг, зориг чадалтай, ухаантай хэн нэгэн удирдагч нь тарж бутарсан омог аймгаа бөөгнүүлж авдаг байсан ба ер нь удирдагчийнхаа чадвараас нүүдэлчин гүрний хүчин чадал ихээхэн шалтгаалдаг байжээ. Нүүдэлчдийн гурван үеийн төр улсын шинж төрхийг судалсан лалын түүхч Ибн Халдун (1332-1406) дүгнэж бичихдээ нүүдэлчдийн анхан үеийн хаад нь өөрсдөө хатуу, чанга байж төр улсаа ч хүчирхэг байлгах эрмэлзлэлтэй байсан бол дараа үеийн хаад нь төр улсын хэрэгт зүтгэхээсээ илүү тансаг суурин амьдралыг мөрөөдөж, зугаа цэнгэлээр хөөцөлдөх болсон ба гуравдагч үеийнхэн нь болохоор төр улс нь гаднын довтолгоог няцаах ч чадалгүй болсон гэжээ.¹⁶

16. World Civilizations: The classical Period in World History Chapter 4. Stearns Peter N; Adas, Michael, Schwartz, Shiart B. 1992 "History of the world"

Нүүдэлчдийн хаад ноёд бүгд тийм биш ч гэсэн Ибн Халдууны ажиглалтыг эрс тэс үгүйсгэх үндэсгүй юм. Байгаль орчин болон цэрэг дайны шалгуурыг давж хувийн чадвараараа тодорсон хаад ноёд нь суурин үндэстнийг захирч байгаад яваандаа хүнд сурталт тогтолцоонд уусч нүүдлийн иргэншлээс хөндийрэн холддог байна.

Нүүдэлчдийн уугуул нутгийн онцлог шинж мал сүрэгтээ билчээр ус сонгох, байгаль, цаг уурын тодорхой нөхцөлд идээшин дасах зэрэг амьдралын шаардлагаас болж тэдний соёл иргэншлээс суурин иргэншилд нэвтэрч үлдсэн нь төдийлэн их бус ажээ. Нүүдлийн эзэнт гүрнүүд дотроос хет, түрэг, монголчуудын эрх баригчид иргэншлийн хувьд нэлээд амжилт олсон байх боловч суурин иргэншлийн удирдлагын тогтолцоог ашигласан байдаг. Ерөнхийд нь авч үзвэл нүүдэлчид гуравдахь үеэсээ хойш суурин үндэстний соёл заншил, түүний хэм хэмжээг хүлээн авч улмаар суурьшмал иргэдэд шингэн уусах болсон ба уусаагүй хэсэг нь монголчууд лугаа адил уугуул нутгийнхаа зүг нүүн оджээ.

Эзэн албатын харьцаа төлөвших яагаачгүй байсан боловч хүчирхэг төр улс байгуулах шаардлага аяндаа гарч байжээ. Эзэн албатын харьцаа суурьшмал нийгмийнх шиг төлөвшиж тогтмолжоогүй болохоор нүүдэлчдийн удирдлагын тогтолцоо нь омог аймгийн тэргүүлэгчдийн хувийн харилцааг түшиглэн байгуулагддаг (Чингис хааны хувьд бол нөхдийн харилцаанд тулгуурлаж байв. Тэр нь дайн дажны үед шалгагддаг байжээ. Нүүдэлчдийн дунд нягт холбоо (конфедерац)-ны удирдагчийг сонгох заншил нь (Голдуу анхан үеийн засаглалын дээрх тогтолцоотой уялдаж байв. Харин ширээнд залах хүнээ сонгох заншил төдийлэн түгээмэл байсангүй. Тийнхүү, Чингис хааныг Хотала хааны хүү Алтан, Нэгун тайшын хүү Хучир, Жүрхэнчүүдийн тэргүүн Сача бэхь нарын Монгол Овог аймгийн удирдагчид харилцан зөвөлсний дараагаар хаан ширээнд залжээ.¹⁷ Энэ мэт эзэн албатын харьцаа нь нүүдлийн төр улсын тогтолцооны сул тал байсан бөгөөд тийм нөхцөлд төр улс тарж бутрах, арилж алга болох аль аль нь хялбархан байжээ.

Ийм утгаараа нүүдлийн улс гүрнийг Марксист онолын ёсоор феодалынх, боолын нийгэмт гэх мэтээр ялган салгаж үзэхэд хялбаргүй. Евроазийн тал нутгийн нүүдэлчин улсууд нь ангийн тэмцлийн дүнд буй болсонгүй, харин улс төрийн тодорхой нөхцөл, тухайлбал: харийн өнгөлзлөгөөс болгоомжилж омгийн аль нэгэн бололцоотой удирдагчаараа толгойлуулсан чөлөөт нягт холбоо байгуулах замаар үүсчээ. Сайн дураараа нийлсэн омог аймгийг зүй ёсоор хүндэтгэж эзэн засаглалд төлөөлөлтэй байхыг зөвшөөрнө.

Харин хүчээр дагуулан нэгтгэсэн омог аймгаа итгэлтэй шинэ удирдагчаар захируулж, найдвар муутай хүмүүст тооцдог байв. Тийнхүү,

нүүдэлчдийн төр улс нь марксистуудын номолдог шиг нэг анги нөгөөгөө дарангуйлах зэвсэг, нийгмийн давхарга үүссэний үр дүн бус харин омог аймгуудын ноёрхолын төлөө тэмцлийн үр дүнд үүсч бүрэлджээ.

Төв Азийн нүүдэлчдийн төр улсуудын дотроос хамгийн онцлогтой нь Монголын эзэнт гүрэн бөгөөд Монголчуудын байлдан дагуулалтыг дан ганц цаг уур, газар зүйн нөхцөл, нүүдэлчдийн түрүү үеийн их нүүдэл сэлтээр тайлбарлбал учир дутагдалтай болно. Байлдан дагуулалтаас хойших үеийн хүн амын тоог авч үзвэл тэдний их нүүдэлтэй төдийлэн холбогдолгүй нь эзлэгдсэн орнуудын хүн амын бүрэлдэхүүнээс илхэн харагддаг юм. Жишээ нь, Чингис хаан Зүчийн хөвгүүд Бат, Орду, Шэйбан нар 4000 Жүрчид (монгол бус), мангад нарыг өгснийг Алтай нуруунаас Карпатын нуруу хүртлэх арвин уудам нутаг дэвсгэртэй харьцуулахад их нүүдэл огт биш нь мэдээж билээ. Мөн түүнчлэн Хулагу хааны 8000 найманчууд ч гэсэн Перс, Дундад Дорнодын бүх хүн амын дэргэд өчүүхэн тоо болно.¹⁸

Дорнын талын нүүдэлчдийн дунд Чингис хааны шинэтгэл засаглалын шинэ зарчмыг нэвтрүүлсэн юм. Чингис хаанаас өмнө засаглалын тогтолцоо нь уугуул овог аймгийн тэргүүн нарын хувийн итгэлцээн эзэн албатын харьцаан дээр тулгуурлаж байсан бол Чингис хаан түүнийг болиулж аравтын тогтолцоо буй болгож албат нараа аравт, зуут, мянгат, түмтэд хуваагаад дарга нарыг нь омог аймгаар бус хувийн чанар, итгэл найдварыг нь харгалзан томилдог журам нэвтрүүлжээ. Хааны эсрэг босохгүй гэж ам тангарагаа өгсөн хишигтэн нар байнгын зэвсэгт хүчин болж байв. Гэтэл Чингис хааны шинэтгэл нүүдэлчид аль хүчтэй, чадалтай хүндээ захирагдамтгай сэтгэлзүйг өөрчилж чадсангүйн тул нүүдэлчид Чингис хааны удмынханд бишрэн захирагдсаныг түүх гэрчилнэ.

4. Үйлдвэрлэлийн нүүдлийн арга Ангийн үүсэл ба, нийгмийн дэвшил

Нүүдлийн нийгэмд хөдөлмөрийн тодорхой хуваарь байдаггүй нь тэдний дунд ангийн үүслийн үйл явц тодорхой биш байдгийн шалтгаан нь болно. Нүүдлийн нийгэмд ноёд язгууртан, бөө удган, малчин, дархчуул гэх мэт ялгаа байсан хэдий ч тийм ялгаа нь суурин нийгмийн ихийг бодвол өчүүхэн бага байжээ.

Чинээлэг ам бүл нь голдуу язгууртан байсан ба тэдний дотор баячуул ч багтах учир суурин нийгмийнхтэй адил бие даасан баян нийгмийн давхрага бий болох хэмжээнд хүрдэггүй байжээ.

Түүхийн материализмд заадаг шиг нийгмийн баялаг үйлдвэрлэх арга нь тухайн нийгмийн хөгжлийн гол хөшүүрэг болдог учир нийгмийн баялгийг бүтээх үйл явцад хүн ам уг нийгмийг бүрэлдүүлж нийгмийн харилцааг тогтоох ба үйлдвэрлэлийн аргаа өөрчилснээр үйлдвэрлэлийн харилцааг өөрчилж

шинэ ангийг төрүүлнэ. Гэвч энэ онолыг нүүдлийн нийгмийн хувьд батлахад хялбар бус болно. Нүүдэл билчээрийн мал аж ахуйн хувиа аргацаасан үйлдвэрлэлийн арга нь сүүн хувьсгалаас хойш өөрчлөөгүй болохоор түүхийн материализмын онолоор бол Хүннүгийн эзэнт гүрнээс хойш нүүдэлчдийн дунд нийгмийн дэвшил гараагүй гэсэн үг юм. Монгол улс нийгэм, эдийн засгийн таван хэлбэршил буюу формацийн хоёрыг алгасч ирсэн гэдгийг марксист түүхчид ч хэлдэг юм. Тухайлбал, боолын болон хөрөнгтний нийгмийг алгасч хөгжсөн нь нүүдлийн нийгмийн түүхэн онцлог болон түүнийг суурин нийгмийн шалгуураар хэмжиж эс болохыг л хэлээд байгаа хэрэг ээ.

Монголын нууц товчооноос бид монголчуудын доторхи баян, хоосны (ядуу) ялгааг харж болно. Ангийн тэмцлийн марксист онолын дагуу бол баячуул-ядуусын хоорондох, ноёд дээдэс болон борчуулын хоорондох зөрчил нь ихэссээр нийгмийн өөрчлөлтөнд хүргэх ёстой билээ.

Гэтэл нууц товчооноос ангийн тэмцэлийг хэн ч олж чадахгүйгээр барахгүй дээдсийн эсрэг босно гэж бодож байсан доодос ядуус нь харин ч дээдсийнхээ төлөө амь насаа зольж гадаад дотоодын дайсантай эрэсдэн тэмцэлдэж эзэд ноёддоо албатын ёсоор морь нохой мэт зүтгэдэг баримт олныг мэднэ. Монголын нууц товчоонд буруу зөрүүд санаа Жамуха, Тогтоа бэхи хоёрын урвалт болно. Гэвч зөрөлтийг ангийн тэмцэлтэй адилтгаж болохгүй нь ойлгомжтой.

Тийнхүү, нүүдлийн нийгэмд үндэсний болон омог аймгийн ноёрхол байснаас биш ангийн тэмцэл байсангүй бөгөөд омог аймаг юмуу тэдгээрийн удирдагч хоорондын зөрчил бол хэрэг дээрээ ангийн тэмцэл биш байв. Нүүдэлчдийн төр улс бүрэлдэх үйл явцыг марксист онолоор тайлбарлах боломж нэгэнт үгүй учир нийгмийн өөрчлөлтийн улс төрийн аргыг орхиж түүнийг байгаль иргэншлийн хандлагаар тайлбарлахыг оролдъё.

Өрнөдийн зарим эрдэмтэд түүний дотор А.Тойнби нүүдлийн нийгэмлэгийг "дэвшил нь зогссон" гэж тодорхойлжээ. Түүнийхээр бол иргэншил гэдэг нь нийгмийн харьцаа, соёл, зан заншил, шашин, урлаг зэргүүдийн цогцолбор бөгөөд Дундад Азийн нүүдэлчдэд Хүннүгийн үеэс хойш дэвшил гараагүй гэжээ.

Суурин нийгэмлэгт зохицохуйн "эзэмших" загварыг сонгож хүрээлэн буй орчноо өөрчилж газар боловсруулах, орон сууц барих зэрэг ажлыг шууд хэрэглэдэг болохоор дэвшлийн шалгуур нь технологийн ололт болдог байна. Тийнхүү, суурин нийгэмлэг нь ангиас гадна янз бүрийн багаж хэрэгсэл, машин, хөдөлгүүр хүртэл зохион бүтээх болсон нь жинхэнэ техник оюуны иргэншилд хүргэж, дэвшлийн гол шалгуур нь технологийн шинэчлэл болжээ. Зохицон амьдрахуйн "дасч идээших" загварыг сонгосон нүүдлийн нийгэмлэгт дэвшлийн гол шалгуур нь технологийн шинэчлэл биш харин байгаль орчноо өөрчлөхийн оронд түүнд зохицон био-систем буй болгохыг чухалчилдаг байна.

Тийм ч учраас нүүдлийн шинжлэх ухаан технологийн шинжлэх ухааныг бодвол биотехнологи (мал эмнэлэг, гаралзүйн сонголт гэх мэт) дээр гол анхаардаг байна. Нүүдлийн иргэншлийн технологийн гол хувьсгал нь:

1. Малыг гэрийн тэжээмэл болгосон явдал бол
2. Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болосн
3. Эмээл хазаар, дөрөө зохион бүтээсэн, эдгээр болно.

Нүүдлийн нийгмийн эдийн засгийн гол нэгж болох гэр бүл, отог аймаг нь аяндаа тогтвортой үргэлжлэх учир технологийн хувьсгал төдийлэн чухал биш байдаг аж. Нүүдэлчид харин мал сүргийнхээ чанарыг сайжруулах замаар гаралзүйн шинжлэх ухаанд багагүй дэвшил хийжээ. Биотехнологийн үр дүнг үзэхэд их цаг хугацаа шаарддаг учраас өөрчлөлт дэвшил нь ч тийм хурдан мэдэгдэхгүй. Бичгийн соёл нүүдэлчдийн дунд хожуу нэвтэрсний дээр боловсролын төвлөрсөн тогтолцоо байсангүй учраас бичиг соёлын уламжлалаа дараагийн үедээ амаар дамжуулан өвлүүлж үлдээжээ. Нүүдэлчдийн дунд нилээд хөгжсөн өөр нэг ухаан бол цэргийн шинжлэх ухаан юм. Энэ нь нүүдэлчдийн явуулж ирсэн ужиг удаан дайн байлдааны шаардлага байжээ.

Суурин нийгэмлэгүүд техно-оюуны иргэншлийг давуу хөгжүүлж, нүүдлийн иргэншил ард нь хоцорсоны шалтгаан нь нүүдэлчдийн дэвшлийн хардац удаан байснаар тайлбарлагдана. Ялангуяа аж үйлдвэрлэлийн хувьсгалаас хойш техно-оюун зонхилох болсноор дэвшил хөгжил технологийн ололтоор хэмжигдэж улмаар суурин амьдрал нүүдлийнхийг ардаа орхижээ.

Ер нь үйлдвэрлэлийн арга нь нийгмийн баялагийг бүтээх гол арга гэдгийг бид мэднэ.

Марксизмд нийгмийг үйлдвэрлэлийн гол аргаар феодалын социалист, капиталист гэж ангилаад үйлдвэрлэлийн энэ арга нь баялагийн хэт үйлдвэрлэлд хүргэж, төр баялагаа хуваахын тул ангиудыг буй болгодог ба хуваарлалт нь нийгмийн хөгжлийн бүх үед социализм, коммунизмаас бусдад нь тэгш бус байдаг гэжээ. Нүүдлийн нийгэмлэгийн баялгаа бүтээдэг аргыг эрхбиш жигд нь авч үзүүштэй. Билчээр, нүүдлийн нийгэмлэгт хоол хүнс, хувцас зэрэг зайлшгүй шаардлагатай эд юмсаа тусгай үндсэн нэгжүүд (гэр бүл, отог аймаг) бэлтгэдгийг дээр дурдсан билээ. Хэрэгцээгээ өөрсдөө хангадаг үйлдвэрлэлийн ийм аргаас гадна хоньчин, адуучин, саальчин, дархчуул гэх мэт хөдөлмөрийн арай төрөлжсөн хуваарь нүүдэлчдэд байсныг бид Монголын нууц товчооноос мэднэ.

Нүүдэлчид харин амьжиргааны гол чухал бүтээгдэхүүнээ өөрсдөө үйлдвэрлээд хувцасны зарим материал, торго, даавуу, тамхи, төмөр эдлэл зэргийг суурьшмал хөршүүдээсээ худалдаа арилжаагаар олж авдаг байжээ. Тэд наймаа арилжаагаар мал, мал аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эд, ангийн олдвор зэргийг оролцуулж оронд нь хэрэгцээтэй бараа авна. Хэрэв худалдаа арилжаагаар олж авах аргагүй бол хүчээр дайралт хийж мал дээрэмдэх явдал

ч цөөнгүй байна. Нэг үгээр хэлэхэд нүүдэлчид амьжиргааныхаа хэрэгцээт зүйлийг суурин иргэдээс арилжаа, дайн тулааны ийм хоёр аргаар л ойртуулдаг байсан гэж болно.

5. Нүүдлийн иргэншлийн уналт

Монголын эзэнт гүрний мөхлөөр нүүдлийн иргэншил уруудаж эхэлсэн гэж хэлж болно. Өрнийн тал нутгийг хар үхэл, тахал өвчин цөлмөн хоосолж тэнд байсан нүүдэлчин аймгууд XV зууны үед ихэд туйлдаж доройтсон байв.¹⁹

Дикое поле буюу Оросоос зүүн тийших зэрлэг талууд тэр үед эзгүйрч, оронд нь зугатмал тариачид (хожим тэднийг кассакууд гэдэг болсон) цагаачлан орж ирэх болжээ.

Гэвч, суурьшмал иргэншлийг шахах явдал XVI зууны үеэс ихэд чангарах болж нүүдэлчид Унгар, Украин, Бага Азийн талуудаас түрэгдэн гарсан юм. Москвагийн их гүн Казань, Астраханийн вант улсуудыг бут цохиод Каспийн Тэнгисийн эрэгт тулж очжээ. Энэ үед нүүдэлчдийн хүч доройтож ирсэн нь тэдний хоорондын эв нэгдэл муугаас шалтгаалсан бөгөөд Монголчууд Хятадыг алдсан нь мөн нэгэн адил хоорондоо эв нэгдэлгүй байсантай холбоотой гэж үзэлтэй.

Галт зэвсэг сайжирч буу цэнэг нум сумнаас давсан нь нүүдэлчдийн хамаг чухал давуу тал болох цэргийн ноёрхлыг үгүй хийхэд хүргэжээ. Гучин жилийн дайны үед (1618-1648) Шведийн Густав Адолф II явган цэргийн бялтат буу өргөн хэрэглэж, их бууны холын тусгал, цэц, ачих зөөх төхөөрөмж сэлтийг нь сайжруулсан тогтмол аримтай болсноос нүүдэлчдийн цэргийн хүч ихэд саарчээ.²⁰ Цаашилбал, Европт аж үйлдвэрийн хувьсгал өрнөж суурин ба нүүдэл иргэдийн хүчний ялгаа улам ихсэхийн зэрэгцээ европт төмөр зам тавигдсан явдал суурьшмал үндэстнүүдийг техник, эдийн засгийн давуу талтай болж нүүдэлчдээс улам их газар унтаг салгаж үүд хаалгыг нээжээ.

Манжуурын талын нүүдэлчин гаралтай манж нар хүчирхэг үедээ Вьетнамын ой шугуйнаас зүүн гарын хаалга хүртлэх өргөн нутгийг байлдан дагуулж байсан хэрнээ Хятадуудад уусч нүүдэлчин шинж чанараа алджээ.

Орос болон Манжийн хятаджсан чин гүрэн хоёр, нэг нь өрнийн тал нутаг руу өнгөлзөж, нөгөө нь дорнын тал нутагруу довтолж явсаар эцсийн эцэст Монголын тал нутагт бие биенээ үзжээ. Түүгээр дэлхийд 3000 жилийн настай нүүдэлчдийн цэргийн ноёрхол өндөрлөж нүүдэлч амьдралын хэв маяг аажмаар алга болж эхэллээ.

Нүүдэлчдийн цэрэг, улс төр аль алины нь талаар захирах болсон

19. Зарим түүхчид тахлыг Аннам, Бирмаас Монгол арми чирч ирсэн гэж тааварладаг боловч Евроазид тахал тараагч янз бүрийн мэрэгчид байдгийг шинжлэх ухаан нэгэнт тогтоожээ. XIV зууны аюулт тарваган тахал ямар ч гэсэн Дорнын талууд бус Өрнийн талуудыг хамарсан нь түүхэнд тэмдэглэгджээ.

20. "Warfare" Microsoft (R) Encarta. Copyright (C) 1994 Microsoft Corporation. Copy right (C) 1994 Funk & Wonnalls Corporation.

суурьшмал үндэстнүүд одоо дараачийнхаа дайралтыг нүүдэлчдийн билчээр мал аж ахуйгаас эхлэх боллоо. Сэргэн мандлын үеэс гүнзгийрсэн шинжлэх ухааны хувьсгал мал аж ахуй, мал эмнэлгийн салбарт нэгэн адил амжилт оллоо. Англид "хонь нь хүнээ иддэг" үеийн зангаар Европт хадлан бордоо тариалах явдал давамгайлж сүүний чиглэлийн Гернсий үнээ үржсэнээр Европт бордооны мал аж ахуй хөгжих боллоо. Үүлдэр шигшилтийн аргыг Европт 1700 оноос ашиглаж эхлэв.²¹

Суурьшмал үндэстнүүд мал аж ахуй эрхлэх аргаа нүүдэлчдийн дунд нэвтрүүлээ.

Транс-Сибирийн төмөр зам тавигдаж Оросууд болон нүүдэлчдийн хөдөлгөөн улам өрнөв. Харин монгол болон манжуурын тал руу хятадын цагаачлалтыг манж нар зөвшөөрдгүй байсан хэдий ч манжийн захиргаа унасанаас хойш, ялангуяа 1911 оны үндэсний хувьсгалын дараагаар дээрх газрууд руу хятадын тариачид үй олноор цагаачлах болов.

Октябрын хувьсгалын дараагаар оросууд нүүдэлчдийг суурьшуулах нөр их туршилтаа Монгол болон казахын тал нутагт эхэллээ. Бүхэл бүтэн нийгмийн туршилтын хажуугаар мал аж ахуйд хийх болсон энэ туршилт нь төдийлэн гайхаш төрүүлээгүй бөгөөд түүнийг анзаарсан хүн ч ховор ажээ. Тийнхүү нүүдэлчид хашаа хороо барьж, хадлан бордоо хураах болжээ. Билчээр, нүүдэл рүү хийсэн сүүлчийн дайралт нь их талуудын атарыг эзэмших хөдөлгөөн байлаа. Мянга мянган комиунистууд Монгол, казахын нутагт газар орныг нь хагалгааны бүсэнд хамруулжээ.

Евроазийн тал нутаг нь цаг уурын хувьд газар тариалан эрхлэхэд эрсдэлтэй нутаг боловч ихээхэн хэмжээний газрыг орчин үеийн техникийн тусламжтайгаар хагалжээ. Тэдгээр нутагт хөрсний эвдрэл, үржил шимтэй үе давхар нь устах зэрэг сөрөг үзэгдэл нийтлэг болжээ.

Мянга мянган жилийн түүхтэй нүүдлийн мал аж ахуй болон иргэншлийн устах явц үргэлжилсээр байна. Нүүдлийн соёл иргэншил цэвэр хэлбэрээрээ үлдэх учиртай юу, эсвэл технологи давуутай суурьшмал иргэншлийг шууд хүлээж авах ёстой юу гэдэг талаар дүгнэлт хийхэд тийм ч хялбар биш асуудал юм. Сайн ч, муу ч орчин үеийн нүүдлийн иргэншил аажмаар суурьшмал иргэншил рүү зүгэлсээр байна. Монголчуудын нийгмийн асар их өөрчлөлт, тэдний сэтгэл зүйн өөрчлөлт нь нүүдлийн нийгэмлэгийн уламжлалтай холбоотой нь гарцаагүй бөгөөд иргэншлийн Монгол загвар нь хоёр иргэншлийг хослуулах хэлбэрээр хөгжих ёстой байж ч магадгүй юм.

Харин нүүдлийн иргэншил сайн уу, муу юу гэдэг бол утгагүй зүйл юм. Хүн төрөлхтний оршихуйн ийм хэлбэр бидний хүсэл эрмэлзлээс хамааралгүйгээр мандан буурсаар өдий хүрч ирсэн бөгөөд хүн төрөлхтний

мэдэгдэхүйц хэсгийн шинж чанар, уламжлал, зан үйл, түүхэн өвийг тодорхойлдог билээ.

6. Цаашид яах вэ?

Монголын тал нутагт суурин нийгэм нэвтэрсэнээс хойш хэдхэн зуун жил өнгөрлөө. Цөөн тооны орд харш, цэргийн бэхлэлттэй монголчууд анхандаа буддын шашны нөлөөн дор сүм хийд барьж түүнийгээ тойруулан хот байгуулалтыг эхэлсэн түүхтэй. Их хүрээ, Эрдэнэ зуу²² мэт хүрээ хийдүүдийн орчимд байгуулагдсан хот сууринд хүн ам бөөгнөрч худалдаа арилжаа, гар урлал зэргийг эрхлэн суух болжээ. 1921 оны үед бүр аж үйлдвэрийн үндэс суурь болсон арьс шир боловсруулах болон хэвлэх үйлдвэрүүд Их хүрээ (одоогийн Улаанбаатар)-нд байгуулагдсан байв.

1921 оны хувьсгалын дараа, ялангуяа 40-өөд оны сүүлчээр монголын нүүдэлчдийг суурьшуулах хөдөлгөөн эрч хүчээ авсан юм. Тэр үеэс оросууд Монголд Европын иргэншлийг түгээн дэлгэрүүлж мал аж ахуй хүртэл суурьшлын хэлбэрт шилжиж байлаа. Өвс ногоо тастахыг цээрэлдэг өнөө Монголчуудыг хадлан бордоо бэлтгэж хашаа саравч барихад хүчээр сургаж, Европын мал эмнэлгийг нэвтрүүлж байв. Тавиад оны үеийн атар эзэмших, хөдөлгөөн хотжуулах үйл явц суурин амьдралыг хурдасгав. Одоо тус орны хүн амын дөрөвний нэг нь хот суурин газар орших ба эрдэнэт, дархан мэт шинэ хотууд байгуулагдлаа. Гэвч өнөөгийн байдлаар монголын мал аж ахуй хагас-суурьшмал хэлбэртэй, газар тариалан нэвтэрсэн, хүн амын хагас нь хот сууринжсан шинж төрхтэй байна.

Цаашид яах вэ? Энэ асуудалд улс төрийн үүднээс биш, эдийн засаг, иргэншлийн талаас нь хандахыг хичээе. Малыг хувьчилсанаас хойш тоо толгой нь байнга нэмэгдэж 30 саяд хүрлээ. Гэтэл билчээрийн даац нь өвлийн улиралд 50 сая, зуны улиралд 80 саяыг тэжээх бололцоотой ажээ.²³ Энэ бол манай билчээрийн цэвэр даац бөгөөд малаа 100% билчээрээр маллахгүй гэж бодоод бүх билчээрээ усжуулсаны дараа ч гэсэн 35-40 сая бол манай билчээрийн мал аж ахуйн байгалийн хязгаарлалт гэсэн дүгнэлт хийж болно.

Билчээрийн мал аж ахуй цаашдаа мал аж ахуйн орчин үеийн фермээр солигдох нь тодорхой юм. Энэ бол эдийн засгийн аргаар явагдах ёстой үйл явц болохоос захиргаа сурталчилгаагаар хийгдэх зүйл биш юм.

Билчээрийн мал аж ахуй эрхэлж амиа борлуулсаар байгаа хүн амын нилээд хэсэг нь төр засгийн толгойд ачаа болохгүй. Орчин үеийн суурьшмал мал аж ахуйг хотуудын мах, сүүний хэрэгцээний дагуу хөгжүүлж болох юм. Мөн ноолуур сайнтай шилмэл ямааг өсгөж болох бөгөөд ноолуур өндөр үнэтэй учир энэ салбарт технологийн шинэчлэл хийж хөрөнгө нэлээд

22. 1634-1787 онд Улаанбаатар нь нүүдэлчдийн суурьшуулсан сонин маягийн нүүдлийн хот байлаа.

23. Энэ талаар нэрт эдийн засагч Цагаанхүү ярилцлагандаа дурджээ.

оруулбал эдийн засгийн хувьд ашигтай. Малчдын туршлагаас үзэхэд тэжээл, өвс ногоо их шилэмтгий учраас ямаан сүрэг нь их эмзэг, хэврэг амьтан юм. Хэрэв эрдэмтэд ямааны ноолуурын чанарыг дордуулалгүйгээр, тэжээлийн бордоо нээж өгвөл их ашигтай байж болно. Тийм нөхцөлд ноолуурын ямааны фермүүд байгуулах чухал эхлэлт болж ямааг их хэмжээгээр үржүүлэх боломж нээгднэ.

Аж үйлдвэржээд ирэх дээр суурьшмал иргэншил Монголыг цаашдаа байлдан дагуулах болно. Тийм учраас бидний гол тактик бол аж үйлдвэржилтийг монголын нөхцөлд тохируулах арга замыг хайж олох, байгаль орчинд нөхөгдөшгүй хор хүргэж хохирол учруулахыг зөвшөөрдөггүй байх, өөрөөр хэлбэл, суурьшмал иргэншлийн өв уламжлалыг хэрхэн яаж "Монголчлох" вэ? гэсэн үг юм. Суурьшмал иргэншил нь нэгэн цагт хүчирхэг явсан дайчин нүүдэлчдийн буурал газар шороонд хөгжлийнхөө замыг яах ч аргагүй улам өргөтгөсөөр ажгуу.

Англиас орчуулсан Э.Пунцаг